

дадлага. чадварыг хөгжүүлэх тодорхой ойлголт өгч ирээдүйд үүсч болох цагийн байдалд ажиллахад бэлтгэгдсэн офицеруудыг бэлдэх нь өнөөгийн эрэлт байж болох юм.

Сургалтын зарчим нь сургалтын процессын удирдамжийг тодорхойлдог бол үйл ажиллагааны дүрэм, заавар журам нь тусгай нэгж, салбар юу хийхийг тусгасан байдаг.

Хилийн албаны сургалтыг хилийн албаны мэдлэг, дадлага, туршлага мөн сургалтын аргаар хослуулан явуулах бөгөөд цэргийн сургалтын зарчим, хэлбэр, арга зүйг эзэмших, сонсогч нарт эзэмшүүлэх нь зүйтэй гэж дүгнэж байна.

Санал:

1. Хилийн албаны хичээлийн хөтөлбөрийн цаг сэдвийн задланд хил судлалын шинжлэх ухааны талаар товч ойлголт гэсэн сэдвийг тусган оруулах

2. Дэлхийн бусад орны хил хамгаалалтын өнөөгийн байдал, ашиглагдаж буй техник хэрэгслийн талаар хичээл орох

3. Цэргийн сургалтын зарчим, тусгай арга, хэлбэрүүдийг судалж, түүний дагуу хилийн албаны мэргэжлийн сургалтын онцлогт тохируулан сургалтыг төлөвлөн зохион байгуулах.

*Д.Алтангэрэл- ХСИС, Хууль сахиулахын
удирдлагын акедамын 8022 дугаар
дамжааны суралцагч, дэд хурандаа*

ТӨРӨӨС УЛСЫНХИЛИЙН ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГО

Сүүлийн үед бүс нутгийн улс төрийн хувирамтгай бөгөөд ээдрээт байдлаас болоод XXI дүгээр зууны дэлхийн хамтын нийгэмлэгт улс бүр хөл нийлүүлэн элсэн ороход тухайн улсын хилийн талаар баримтлах бодлого нь маш чухлаар тавигдах боллоо. Улс төрийн болон хил орчмын цагийн байдлын өрнөлөөс үүдэж улс бүр өөр өөрийн хил хамгаалах бодлого. үйл ажиллагаа явуулж байна.

Зарим улс нутаг дэвсгэрээ тойруулан “төмөр хөшиг” татах, зарим нь зөвхөн шалган нэвтрүүлэх боомтуудад эрх зүйн ба хамгаалалтын арга хэмжээ эрхэмлэх, гуравдах орон улсын хилээ “тунгалаг” байлгахыг хичээх, дөрөвдөх нь зэргэлдээ улс орны улс төр, эдийн засаг, нийгмийн байдал, хөрш оронтой харьцах харьцаанаас үүдэн зохих хэмжээний дундаж хамгаалалттай байлгах бодлого баримталж байна. Улс гэдэг ойлголт нь тухайн орны тусгаар

тогтнолын баталгаа болсон хэм хэмжээ, мөрдөгдөж буй хууль, эрх зүй бүрэн төгс үйлчилдэг нутаг дэвсгэртэй. түүнийгээ заагалсан хилтэй байх ёстой гэдгийг бид бүгд мэдэх билээ.

Зарим орнуудын хоорондох улсын хил нь “ёс төдий” боловч. зарим орны хоорондох хил нь “хятадын цагаан хэрэм” шиг байгаа. Гадаад, дотоодын нөлөөлөх хүчин зүйлээс болоод зарим орон улсын хилийг хэсэгчилсэн байдлаар хамгаалалт явуулдаг арга ч бий. Дэлхий нийтээр даяаршиж байгаа өнөө үед улсын хилийг ямар байдлаар хамгаалах, түүний эрх зүйн орчин, төрөөс хилийн талаар баримтлах бодлого ямар байх талаар өөр өөрийн онцлогтой боловч тэр нь шинжлэх ухааны үндэслэлтэй, эрх зүйн зохицуулалттай, онолын болон агуулга, хэлбэрийн хувьд ижил байдаг байна. Тиймээс би судлаач хүний хувьд өндөр хөгжил бүхий улс орнуудын төрөөс улсын хилийн талаар баримталж буй бодлогын тухай зарим нэг ойлголтуудыг та нөхөдтэй хуваалцахыг хичээсэн болно. Төрөөс хилийн талаар баримтлах бодлогыг улс орны аюулгүй байдлын /үндэсний аюулгүй байдал/ үзэл баримтлал болон улс төрийн бодлогын салшгүй хэсэг байх ёстой гэж дэлхийн хамтын нийгэмлэг үздэг байна. Энэхүү бодлогын үндэс нь улсын хилийн аюулгүй байдлыг хангах механизм, түүнийг хэрэгжүүлэх зорилго, зорилт, зарчим, үндсэн чиглэлийн талаар албан ёсоор хүлээн зөвшөөрөгдсөн үзэл санааны /бодлын/ тогтолцооноос бүрддэг байна. Төрөөс хилийн талаар баримтлах бодлогын эрх зүйн үндэс нь тухайн орны үндсэн хууль, бусад хууль тогтоомж болон олон улсын эрх зүйн бүх нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн норм, зарчимуудаар тодорхойлогдоно. Энэхүү бодлогыг хил хязгаарын хүрээнд /хил орчмын нутаг дэвсгэрт/ төрийн болон орон нутгийн засаг захиргааны байгууллага, төрийн бус байгууллага, хувь хүнээс өөрт оногдсон эрх зүйн хэмжээнд зорилго чиглэлтэй, зохицуулалттай үйл ажиллагаа явуулсанаар хэрэгжүүлдэг. Энд дурдагдсан хил хязгаарын хүрээ /хил орчмын нутаг дэвсгэр/ гэж тухайн орны үндэсний эрх ашиг ба хилийн аюулгүй байдлыг зайлшгүй хамгаалах, улсын хилийн баталгаажилт, хамгаалалтаас үүдэлтэй үзэгдэл, үйл явц бусад хүчин зүйлээр тодорхойлогддог, улс нийгэм, хувь хүний амьдралын эх үүсвэр болсон хилийн тэр орчинг /хил орчмын нутаг дэвсгэрийг/ хэлж байгаа юм.

Төрөөс хилийн талаар баримтлах бодлогын мөн чанар нь төрийн байгууллагууд хуулиар хүлээсэн тал бүрийн үйл ажиллагаагаа хил орчимд хэрэгжүүлэхэд оршдог бөгөөд тэр нь тухайн улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, газар нутгийн бүрэн бүтэн байдал, улсын хилийн халдашгүй дархан байдлыг хангах, хилийн аюулгүй байдал, улсын эрх ашигийг өөрийн хил орчмын нутаг дэвсгэрт хамгаалахад чиглэгдэнэ. Хилийн талаар баримтлах

бодлого нь улсын хилийн шугамаас эхлээд хил орчим нутаг дэвсгэрт байгаа хил хамгаалах байгууллагын бүх объект, хил орчмын газар нутаг, агаарын хилийн хэсэгт үйлчилдэгээс гадна дээрх газар нутгийн хүрээнд улс, нийгмийн харилцаа. амьдралын үйл ажиллагаанаас үүссэн асуудлыг шийдвэрлэх удирдлагын баримт бичиг байхаас гадна тухайн орны хил орчимд нөлөөлөх дотоод, гадаад хүчин зүйл, газар нутгийн маргаан, хил орчмын зөрчилдөөнт байдал, хоёр улсын хоорондын мөргөлдөөнд хүргэх аюул зэргээс урьдчилан сэргийлэх, хил дамнасан зэвсэг, хар тамхи, хүний наймаа, зохион байгуулалт бүхий гэмт хэргийн бүлэг, хууль бус дүрвэгсэд орж /ирэх буюу гарах болзошгүй ажиллагаанаас улсын хил, хил орчмын нутаг дэвсгэрээ хамгаалах эрх зүйн үндсэн баримт бичиг болдог. Улс бүхэн төрийн тэргүүнээр (Улсын Их Хурал) батлуулсан хилийн талаар баримтлах бодлогын үндэстэй байх ёстой гэдгийг ихэнхи улс төрчид, бодлого боловсруулагчид, судлаачид үздэг байна. Энэхүү баримт бичигт хил орчмын нутаг дэвсгэрт үүсч болох хилийн зөрчил, будилааныг тайван замаар шийдвэрлэж болох төрийн бодлогын үндсэн чиглэл бүрэн туссан байх ёстой. Хилийн талаар баримтлах бодлогын үндэс баримт бичиг нь улс төрийн болон практик ач холбогдлын хувьд:

- гүйцэтгэх засаглалын бүх шатны байгууллагуудад хил орчмын нутаг дэвсгэрт улс төрийн нэгдсэн бодлого, албан ёсны байр сууринаас нэгдмэл үйл ажиллагаа явуулах боломж олгоно;

- хилийн аюулгүй байдлын талаар улс төрийн удирдагч нар, яам, агентлагуу- дын удирдлагуудыг нэгдсэн бодлогоор хангана;

- хил орчмын нутаг дэвсгэрт улс орны үндэсний язгуур ашиг сонирхлыг хангах бодитой, үр ашигтай арга хэмжээ авах эрх зүйн орчин бүрдэнэ;

- цаг үеийн шаардлагын дагуу урган гарсан асуудлыг шинжлэх ухааны үндэстэй шийдвэрлэхэд албан ёсны үзэл баримтлал, эх сурвалж болдог;

- улс орны тэргүүн нарт улсын хилийн талаарх бэрхшээлтэй хэцүү асуудлуудыг шийдэхэд товч тодорхой ойлголт өгч, хил орчмын нутаг дэвсгэрт үндэсний язгуур ашиг сонирхлыг хамгаалах, өөрийн орны аюулгүй байдлыг хангах, хамтран ажиллах, харилцан зэрэгцэн орших бүх талын арга хэмжээ авах үндэс болно. Хилийн талаар баримтлах бодлогодоо тухайн орны төр, засгаас хилийн үйл ажиллагаа явуулах нэгдмэл зорилго, зарчим, үүрэг, үндсэн чиглэл, тэдгээрийг хэрэгжүүлэх механизмыг тодорхойлдог байна. Хилийн бодлогын нэгдмэл зорилго нь үндэсний (төрийн) язгуур өрх ашигийг хамгаалах, хэрэгжүүлэх, хилийн орон зайд гадаад, дотоодын аюул заналаас төр, нийгэм, хувь хүн, чухал объектийн аюулгүй байдлыг хангах, хилийн талаар байгуулсан улсын болон олон улсын гэрээ хэлэлцээр, эрх зүйн хэм хэмжээг сахих, зэргэлдээ улстай хамтын ажиллагааг хөгжүүлэх бүх талын бололцоо

олгоход оршино. Дээрх нэгдмэл зорилго нь түүний үндсэн үүргээр тодорхойлогдоно. Орчин үед төрөөс хилийн талаар баримтлах бодлогын үндсэн үүрэг нь:

- тухайн улс орны тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн болон улсын хилийн аюулгүй байдлыг хангах бүх нөхцөлийг бүрдүүлэх;

- улсын хилийн талаарх олон улсын эрх зүйн баримт бичгийг боловсронгуй болгох;

- улсын хил дээр болон хил орчмын нутаг дэвсгэрт цэргийн аюул, хурцадмал байдал, зэвсэгт ба зэвсэггүй мөргөлдөөн гарахаас урьдчилан сэргийлэх талаар улс хоорондын хэлэлцээр байгуулах;

- бусад улс орны /зэргэлдээ улс/ зүгээс өөрийн орны нутаг дэвсгэрт хүчээр шилжин суурьших, эдийн засгийн түрэмгийллийн эсрэг чиглэсэн арга хэмжээ авах;

- улсын үндэсний эрх ашгийн үүднээс хилийн орон зайд цэрэг улс төрийн бүлэглэл болон бусад гадны олон улсын зүгээс тусгаарлагдмал байдалд орох аюулыг арилгах;

- ямарч хэлбэрийн гэмт хэргийн үйлдлийг (санаатайгаар улсын хил зөрчих, хууль бусаар буу зэвсэг, мансууруулах бодис, эд зүйлс нэвтрүүлэх, хил дамнасан гэмт бүлэг орж ирэх г.м) таслан зогсоох чадвартай болгохын тулд улсын хил хамгаалалтыг бэхжүүлэх;

- улсын тусгаар тогтнол, түүний материаллаг болон оюуны баялгийн эсрэг ямарч үйлдлийг таслан зогсоох;

- улсын хилийн баталгаажилт, хамгаалалт эрхэлсэн байгууллагуудыг хөгжүүлэн, ялангуяа улсын хилийн болон хил орчмын хамгаалалтыг сайжруулах;

- улсын хил болон хил орчмын нутаг дэвсгэрийг хамгаалах үүрэг бүхий субъектүүдийн нэгдмэл ажиллагааг хангах;

- хамгаалалт эрхлэх бүх субьектийн алба, байлдааны болон бусад боломжийг дээшлүүлэх, бэлэн байлгах арга хэмжээ авах. Хилийн талаар баримтлах бодлогын зорилго, үндсэн үүрэг нь тодорхой зарчимуудад суурилдаг ба номлолын хэлбэртэй байдаг байна. Ардчилсан ямарч орны хилийн талаар баримтлах бодлого нь доорх зарчимуудад тулгуурлана. Үүнд:

- бие биенийхээ тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, улсын хилийн халдашгүй дархан байдлыг хүндэтгэх; хилийн орон зайд тухайн орны үндэсний (улсын) эрх ашигийг хамгаалах, түүнийг хэрэгжүүлэх иж бүрэн арга хэрэгсэлтэй байх;

- хилийн асуудлаар бий болсон маргаан, будилааныг тайван замаар шийдвэрлэх;

- хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх.

Хилийн талаар баримтлах бодлого нь үйл ажиллагааны үзэгдэл болохын хувьд өөрийнхөө зорилго. үндсэн үүргээ тодорхой чиглэлээр дамжуулан хэрэгжүүлнэ. Үүнийг олон улсын жишигт нийцүүлэн сийрүүлбэл:

- нутаг дэвсгэрийнхээ хил хязгаарыг баталгаажуулах;

. улсын хилээ олон улсын эрх зүйн хэм хэмжээнд нийцүүлэн тогтоон тэмдэглэх;

- хилийнхээ аюулгүй байдлыг хангах;
- хил орчимд улс хоорондын хамтын ажиллагааг хөгжүүлэх;

• хил орчмын нутаг дэвсгэрт амьдарч буй хувь хүн, иргэд, үйл ажиллагаа явуулж буй бүх шатны байгууллагын нийгмийн асуудлын хөгжлийг улам хурдасгах;

• хил орчмын нутаг дэвсгэрийг хөгжүүлэх шинжлэх ухааны үндэслэл, эрх зүйн орчныг төгөлдөржүүлэх.

Хилийн талаар баримтлах бодлогын үндсэн чиглэлүүдийн цөм нь хилийн аюулгүй байдлыг хангах явдал мөн.

Хилийн аюулгүй байдал гэдэг нь тухайн улсын аюулгүй байдал (үндэсний аюулгүй байдал)-ын нэгдэл бөгөөд шууд ба шууд бус гадаад, дотоодын аюул заналаас улсын хилийн орон зайд улсын хил, хил орчмын нутаг дэвсгэр, эдийн засаг, цэрэг-стратегийн, нийгэм, соёлын болон бусад чухал объектийн найдвартай хамгаалагдсан байдал юм. Хилийн талаар баримтлах бодлого нь хэрэгжүүлэгч субъектүүдийн харилцаа, үндсэн объектуудийн хамгаалалтыг зохицуулдаг тодорхой хууль тогтоомжид тулгуурладаг байна. Жишээ нь: улсын хилийн тухай хууль дээрх бодлогыг хэрэгжүүлэгч үндсэн субъектүүд нь

- төрийн байгууллагууд /гадаад харилцааны, дэд бүтцийн, сангий, цэргийн, хуулийн, тагнуулын, шүүхийн, цагдаагийн/;

- орон нутгийн засаг захиргааны байгууллагууд;

- төрийн бус байгууллагууд;

. иргэд.

Эдгээр субъектүүдийн эрх, үүргийг төрийн хууль, тогтоомжоор тодорхойлно. Харин хилийн талаар баримтлах бодлогын үндсэн объектуудад улсын хил, хилийн бүс, хил орчмын нутаг дэвсгэрт байгаа улсын ашиг, сонирхол бүхий улсын стратегийн объектууд орно. Хилийн талаар баримтлах бодлогыг төрийн анхааралд зайлшгүй байх үндсэн чиглэл, үндэсний хэмжээний болон бүс нутагт хэрэгжүүлэх арга хэмжээг тусгасан тусгай хөтөлбөрөөр амьдралд хэрэгжүүлдэг. Зарим орны туршлагыг харахад хилийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх хөтөлбөрт урт хугацааны буюу хэтийн

чиглэлийг тогтоосон үндсэн (улсын хэмжээний) хэсэг болон өдөр тутам хэрэгжиж байдаг арга хэмжээг тусгасан практик (бүс нутгийн) хэсгээс бүрддэг байна. Энэхүү хөтөлбөрийн дээрх хоёр хэсэг нь агуулгын хувьд хилийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх үндсэн механизмыг бүрдүүлэх ёстой. Хилийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх хөтөлбөр нь яам, тусгай газруудын үйл ажиллагааг нэгтгэн зангидсан, олон талыг харсан иж бүрэн баримт бичиг мөн. Өөрөөр хэлбэл түүний гол агуулга нь улсын хил болон хил орчмын нутаг дэвсгэрт хил хамгаалах нэгдсэн тогтолцоо, улсын ашиг сонирхлыг хангах, хил хяналт, хамгаалалтын байгууллагуудаас хилийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх хөтөч, эх сурвалж байх ёстой. Төрөөс хилийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх хөтөлбөрт дараах шаардлага тавигдана.

- хил хамгаалалтын үйл ажиллагаа явуулах өөрийн бодит байдалд тулгуурлан хэрэгжүүлэх арга хэмжээний үндсэн зорилго, чиглэлийг зөв тодорхойлох;

- үйл ажиллагааны олон арга хэлбэрийг сонгосон, тэдгээр нь үндэслэлтэй байх;

- хил орчимд үүсч болзошгүй нөхцөл байдлын үед ажиллах шинэлэг арга барил, чиглэлийг тусгасан байх;

- хэрэгжүүлэх явцад түүнийг зогсоох, өөрчлөх боломжтой байх;

- шаардлагатай үед зарим нэг чиглэлийг түлхүү хөгжүүлэх;

- хөтөлбөрийг үндэслэн бүс нутгийн хамгаалалтын талаар нэмэгдэл арга хэмжээг авах эрх зүйн үндэс байх.

Ямарч улс орны хилийн бодлогыг хэрэгжүүлэх төлөвлөгөөний үндсэн чиглэл нь:

- улсын ашиг сонирхлын эсрэг ямарч аюул заналыг улсын хил дээр тогтоон барих, арилгах;

- улсын хил болон хил орчмын нутаг дэвсгэрийн цагийн байдалд бүрэн хяналт тавих;

- хоёр улсын хилийн харилцааг зохицуулах. хилийн орон зайд бий болсон зөрчилдөөнт байдлыг улс төр, дипломат соло иэргийн бус аргаар шийдвэрлэх;

- улсын хил дээр үүссэн аюул зачалыг найдвартай арилгах арга хэлбэр, үйл ажиллагааг хүчний байгууллагатай хамтран идэвхитэй явуулах;

- ямарч цагийн байдал үүссэн ч түүнийг сөрөн зогсох хүч хэрэгслийг ээлж дараалан бий болгох.

Дэлхийн өндөр хөгжилтэй орнуудад хилийн талаар бодлогын хэрэгжүүлэлтийг төлөвлөхдөө дараах логик дарааллыг баримталдаг: зорилго, зорилт, зарчим, арга, арга зүй, хэтийн чиглэл, төлөвлөгөө, хөтөлбөр. Эдгээр нь улс төрийн, эдийн засгийн, нийгмийн, цэргийн, мэдээллийн, соёлын, хилийн.

угсаатны, дүрвэгсдийн болон бусад олон тооны арга хэмжээг өөртөө багтаасан, хоорондоо уялдаа бүхий иж бүрэн механизмын тогтолцоог бүрдүүлдэг байна. Хилийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх үндэсний хэмжээний (улсын) хөтөлбөр нь тус бодлого баримт бичгийн салшгүй хэсэг бөгөөд түүнийг холбогдох субъектүүдийн хамт хилийн болон хил орчмын нутаг дэвсгэрт хэрэгжүүлснээр улсын хилийн аюулгүй байдал, улмаар улсын тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал хангагдах юм.

*А.Ариунзориг- ХСИС, Хууль сахиулахын
удирдлагын академийн 8022 дугаар
дамжааны суралцагч, хошууч*

*В.Пүрэвбаасан -ХСИС, Хууль сахиулах удирдлагын
академийн Хилийн албаны удирдлага, стратегийн
профессорын багийн дэд профессор, хурандаа*

ХӨРШ ОРНУУДЫН ТӨРӨӨС ХИЛИЙН ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГО ХИЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛД НӨЛӨӨЛӨХ НЬ

Хураангуй. Энэхүү нийтлэлээрээ хөрш орнууд (ОХУ)-ын төрөөс хилийн талаар баримтлах бодлогыг хэрхэн гаргаж тавьсан, хилийн аюулгүй байдлыг сахин хамгаалах арга хэмжээг хэрхэн авч хэрэгжүүлж байгааг харуулахыг зорилоо.

Түлхүүр үг. Оросын холбооны улсын төрөөс хилийн талаар баримтлаж буй бодлого, Бүгд найрамдах хятад ард улсын төрөөс хилийн талаар баримтлаж буй бодлого.

Оросын Холбооны Улс /ОХУ/ нь Евразийн орон юм. Орос нь ерөнхийлөгчийн засаглалт бүгд найрамдах, 83 харьяат субъектээс бүрдэх холбооны улс юм. Орос нь өргөн уудам нутагтай учир баруунаас зүүн тийш Норвеги, Финлянд, Эстон, Латви, Шитва, Польш, Беларусь, Украин, Гүрж, Азербайжан, Казахстан, Хятад, Монгол, Хойд ролонгос гэх олон улстай хил залгана. Мөн усаар зааглагдаж, АНУ-н Аляска муж, Швед, Дани, Турк, Япон улсуудтай хиллэдэг.

Дэлхийн хамгийн том 17,075,400 хавтгай дөрвөлжин километр газар нутагтай, хүн ихээр суурьшсан 8 дахь буюу нийт 143 сая хүнтэй улс юм. Оросын газар нутаг Хойд Азийг бүхэлд нь, Европын 40 хувийг бүрхдэг. хөндлөнгөөрөө 9 цагийн бүсэд хуваагддаг. байгалийн өвөрмөц тогтоц бүхий уудам газар нутагтай. Мөн дэлхийд эрдэс баялаг ба эрчим хүчний эх үүсвэр.